



**ХЭНТИЙ АЙМГИЙН
МӨРӨН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 08 сарын 12 өдөр

Дугаар 4/119

Мөрөн сум

┌ Мал угаалгын ажлыг зохион байгуулах ┐
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3.1, Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын 2024 оны 01 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ :

1. Сумын хэмжээнд нутаглаж буй үхэр бог малыг шимэгдэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалгыг 2024 оны 07 дугаар сарын 25-ны өдрөөс эхүүлэн 09 дүгээр сарын 30-нд багтаан чанартай зохион байгуулж хариуцлагатай ажиллахыг мал эмнэлгийн нэгжийн эмч нарт үүрэг болгосугай.

2. Мал угаалгын ажлын явцад хяналт тавьж үүрэгжүүлэн, малчдад мэдээлэл хүргүүлэн ажиллахыг багийн Засаг Дарга нарт даалгасугай.

3. Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6, 21 дугаар зүйлийн 21.1, 21.3.1-д заалтын дагуу мал сүргээ угаалгад бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийж, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бий болгосон хүмүүст холбогдох хуулийн хүрээнд хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн Улсын байцаагч (Т.Жавхланттөгс)-д даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Сумын Засаг Даргын Орлогч (Б.Мягмаржав)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Ц.БАТЦООЖ